

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Бараа материал	8
2.8.4 бусад эргэлтийн хөрөнгө	9
2.8.4 Үндсэн хөрөнгө.....	9
2.8.5 Өр төлбөр.....	10
2.8.6 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал.....	13
3.1 авлагын данстай холбоотой асуудал.....	13
3.2 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	13
3.3 төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	14
3.4 харьяа газуудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал.....	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	16
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.25 № 01/931
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.ЦАГААНХҮҮ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_KhereglYawsan_Bichig\2020\0325SAG6.Docx

001051658

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Цагаанхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, авлагыг барагдуулах, төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарцуулах, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 05-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор А.Даваадорж, гэрээт аудитор Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 01/582 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар эрхэм зорилгоо Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино гэж тодорхойлсон ба дараах стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн байна. Үүнд:

- Холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх актын биелэлтэд тавих эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;
- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчныг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэргэжлийн хяналтыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны удирдлагыг хангах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх мэдээллийн технологийг нэвтрүүлэх;
- Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа, ажлын үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг сайжруулах, авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 оноос хойш холбогдох стандарт,

журмын дагуу шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, журам мөрдөгдөхгүй байх зэрэг үр дагавартай байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хууль зүй, мониторингийн хэлтсийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй танилцахад Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын 2018 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргаж зөвлөмж өгч, гүйцэтгэл, үр дүнг хангуулах гэсний дагуу хяналт шалгалт хийж дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр, танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2020 оны 01 дүгээр сард 01/360 тоот албан бичгээр хүргүүлсэн байна. Үүнээс санхүүгийн аудитаар 2 аймагт 8.9 сая төгрөгийн зөрчил илэрч 5.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 13 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 43,466.4 сая төгрөгийн 1 хувь буюу 434.7 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 27 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 23 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 22 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,006.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,635.9 сая төгрөгийн 17 алдааг аудитын явцад залруулж, 29.6 сая төгрөгийн 9 зөрчилд

төлбөрийн акт тогтоож, 59.7 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 280.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 37 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 133.4 сая төгрөгийн өр төлбөрийг дутуу, урьдчилж орсон орлогыг илүү, нэр данс зөрүүтэй 0.4 сая төгрөгийн гүйлгээг цэвэр дүнгээр нэгтгэсэн.
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 432.0 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт шилжүүлгийг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 400.0 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардлыг тус тус илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 31.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт дансыг илүү, үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт дансыг дутуу, 25.8 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулгыг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 432.4 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт шилжүүлгийг тус тус илүү нэгтгэсэн.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт

Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын гадна зам, талбайн тохижилтын ажлын санхүүжилт 15.5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулж, 2016 оноос хойш үлдэгдэлтэй байна. Гэвч уг барилгын гадна талбай нь нийтийн эзэмшлийн талбай болохыг тус аймгийн Мэргэжлийн хяналтын газрын автозамын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-д "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавих

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 21.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгахаар өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 971.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 638.9 сая төгрөгийн 14 алдааг аудитын явцад залруулж, 14.1 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 59.7 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 259.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 33 зөвлөмжийг хүргүүллээ.

2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 149.3 сая, эцсийн үлдэгдэл 374.8 сая төгрөг болж, 225.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.3	0.3
Банканд байгаа бэлэн мөнгө	149.3	374.5	225.3
Замд яваа мөнгөн хөрөнгө			0.0
Хадгаламж			0.0
Дүн	149.3	374.8	225.5

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 2.9 сая төгрөг арилжааны банк дахь дансанд, 331.2 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 40.4 сая төгрөг ахмадын сангийн дансанд, 0.3 сая төгрөг мөнгөн кассын дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Барьцаа хөрөнгийн дансанд хэрэгжээгүй ажлын санхүүжилтийг байршуулсан, жижиг мөнгөн санг журмын дагуу ажиллуулаагүй, шууд хамаарал бүхий албан тушаалтанд ажил хавсруулан гүйцэтгүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан нийт 131.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. *Тухайлбал:*

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын гадна зам, талбайн тохижилтын ажлын санхүүжилт 15.5 сая төгрөгийг 2016 оноос хойш хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан,
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар тусгай зориулалтын тоног төхөөрөмж худалдан авах 107.8 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа дэнчингийн дансанд байршуулсан, нягтлан бодогчийг мөнгөн хөрөнгийн кассын нярваар хавсруулан ажиллуулсан, ЖМС-ийн зарцуулалтын эрхийг оны эхэнд их дүнгээр авснаас бэлэн мөнгөний үлдэгдэл ихтэй,
- Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар 6.0 сая төгрөгийн 16 ажил гүйлгээг хийсэн.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 57.9 сая, эцсийн үлдэгдэл 39.5 сая төгрөг болж, 18.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.0	0.1	-0.9
Бусад авлага	56.9	39.4	-17.5
Дүн	57.9	39.5	-18.4

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, он удаан жил болсон, эзэн холбогдогчгүй 39.2 сая төгрөгийн авлага санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. */Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 0.8 сая, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн 24.3 сая, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 2.3 сая төгрөг/*

2.9.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,801.3 сая, эцсийн үлдэгдэл 2,943.0 сая төгрөг болж, 141.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	159.9	142.4	-17.5
Эм боох материал	339.8	355.6	15.8
Бэлэн бүтээгдэхүүн	95.0	85.3	-9.7
Хангамжийн материал	2,205.5	2,358.6	153.1
Мал амьтад	1.1	1.1	0.0
Дүн	2,801.3	2,943.0	141.7

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 141.7 сая төгрөгөөр өмнөх оноос өсөхөд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн бараа материал 105.3 сая төгрөгөөр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бараа материал 56.0 сая төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

2.9.4 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 3,397.4 сая төгрөгийн 2 аймгийн конторын болон лабораторийн барилга бусад эргэлтийн хөрөнгийн нөөцийн бараа материал дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газар санхүүгийн тайланд эм боох материалыг хангамжийн материал дансанд бүртгэсэн, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

2.9.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 31,577.5 сая, эцсийн үлдэгдэл 31,563.3 сая төгрөг болж, 14.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	19,228.5	20,014.9	786.4
Авто тээврийн хэрэгсэл	891.5	1,045.1	153.6
Машин тоног төхөөрөмж	7,452.9	6,092.3	-1,360.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	870.0	1,015.6	145.6
Зам, гүүрийн байгууламж	128.7	4.9	-123.8
Дуусаагүй барилга	53.0	53.0	0.0
Бусад хөрөнгө	1,218.8	1,417.6	198.8
Ном	6.9	6.9	0.0
Үндсэн хөрөнгийн дүн	29,850.3	29,650.3	-200.0
Программ хангамж	239.3	299.8	60.5
Бусад биет бус хөрөнгө	1,487.9	1,613.2	125.3
Биет бус хөрөнгийн дүн	1,727.2	1,913.0	185.8
Дүн	31,577.5	31,563.3	-14.2

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 901.4 сая, шинээр ашиглалтад орсон барилга 1,323.8 сая, мэргэжлийн хяналтын нэгжүүд хооронд балансаас балансад шилжүүлэн авсан 224.3 сая, үнэ төлбөргүй, хандиваар авсан 3,149,3 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба балансаас балансад шилжүүлсэн 413.4 сая, акталсан 1,360.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны 52.9 сая төгрөгийн үлдэгдэлд 2 аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын зураг төсвийн үнэ 52.0 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 0.9 сая төгрөгийн мод тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 онд Гадаадын иргэн харьяатын газраас шилжүүлж авсан Land cruzeer автомашиныг үйл ажиллагаандаа ашиглаагүй,

Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй 955.8 мянган төгрөгийн хөрөнгө "мод" бодитоор байхгүй,

Харьяа газруудад ашиглагдаж байгаа "Интер актив Би Ай" ХХК-ийн Санхүүгийн программ нь ажиллагсдын цалингийн картыг тусад нь бодож хэвлэдэггүй, гараар карт хөтлөн ашигладаг, нийгмийн даатгал, татвар, өмч, шилэн дансны цахим системд мэдээлэл солилцох боломжгүй, НББ-ийн журналууд баталсан маягтаар хийгдээгүй, аудитын СТАУС цахим системд нийцээгүй, ойлгомжгүй, мэдээ тайлан гаргах болон санхүүгийн тайланг хөрвүүлэхэд хүндрэлтэй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын шаардлагад нийцэхгүй байна. /Нийслэл, Дархан-Уул, Булган, Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газар/

2.9.6 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 128.8 сая, эцсийн үлдэгдэл 331.3 сая төгрөг болж, 202.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн			
Өглөг	0	0.1	0.1
Ажиллагсадтай холбогдсон өглөг		0.1	0.1
Бусад өглөг	0.1	331.1	331.0
Урьдчилж орсон орлого	128.7		-128.7
Нийт дүн	128.8	331.3	202.5

Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 331.2 сая төгрөгийн барьцаа, 0.1 сая төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өглөг байна.

2.9.7 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 35,519.0 сая, эцсийн үлдэгдэл 37,998.1 сая төгрөг болж, 2,479.1 сая төгрөгөөр байна.

Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,432.7	16,432.7	-
Хуримтлагдсан үр дүн	16,018.6	18,562.0	2,543.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,009.1	2,977.5	(31.6)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	58.6	25.9	(32.7)
Дүн	35,519.0	37,998.1	2,479.1

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт данс тайлант онд 6 аймгийн мэргэжлийн хяналтын газар дахин үнэлэгдсэн хөрөнгө акталж устгаснаас 31.5 сая төгрөгөөр нэмэгдэж, шүүхийн шийдвэр болон, холбогдох баримтаар авлага данснаас хассанаас 5.6 сая төгрөгөөр хасагдаж нийт 25.9 сая төгрөгөөр өөрчлөлт орсон байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 2,950.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4,211.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 160.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ариутгалын хураамжийн төлбөр	1,764.2	2,419.2	(655.0)	137.1
Лабораторийн шинжилгээний орлого	1,185.8	2,139.4	(953.6)	180.4
Бусад /Орон нутагт төвлөрүүлэх гэрчилгээ, мэдэгдлийн төлбөр/		188.8	(188.8)	0.0
Нийт дүн	2,950.0	4,747.4	(1,797.4)	160.9

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын орлого 1,797.4 сая төгрөгөөр давсан нь хилээр нэвтэрч буй ачаа, эргэлт, лабораторийн шинжилгээний тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор ариутгал, халдваргүйжүүлэлтийн хураамж, шинжилгээний орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 35,936.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 32,996.6 сая төгрөгийг урсгал зардалд, 2,939.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 35,733.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 202.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 35,664.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 68.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон ба гүйцэтгэлээр 33,656.1 сая төгрөгийг зарцуулсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 205.8 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 2.9 сая төгрөгөөр давсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 33,656.1 сая төгрөг гарч 93.7 хувийн биелэлттэй оны эцэст үндсэн үйл ажиллагааны орлогоос 107.7 сая, урсгал зардлын санхүүжилтээс 2,211.3 сая нийт 2,319.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нийт 2,279.9 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь дараах голлох шалтгаантай байна. Үүнд:

- Загийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэвэрт гарсан, жирэмсэн амаржсан, хүүхдээ асрах чөлөөтэй байгаа ажилтны орон тоонд хүн нэмж аваагүй, орон нутагт тусгай мэргэжил шаардсан ажлын байранд шаардлага хангасан мэргэжилтэн олдохгүй байгаатай холбоотойгоор орон тоо дутуу ажилласнаас цалин НДШ-ийн зардал 1,733.8 сая төгрөгөөр;
- Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 294.1 сая төгрөгөөр;
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, батлагдсан төсвөөс 68.3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс тус тус голлон шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 2,939.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,471.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, 400.0 сая төгрөгийг орон нутагт эрх шилжүүлж, 73.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд, захиалагчийн хяналтын дансанд 58.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 2 байгууллага, аж ахуйн нэгжээс 103.0 сая, гадаад төсөл хөтөлбөрөөс 13.2 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 390.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 16.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,349.8 сая, нийт 1,873.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс, НДШ-д 171.8 сая, бараа, үйлчилгээний бусад зардалд 754.0 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 108.6 сая, хөрөнгийн зардалд 288.0 сая төгрөг нийт 1,322.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 550.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 11.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хэрэгжих шатандаа байна.

Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 АВЛАГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт:

Авлагын үлдэгдэлд 2006-2013 онуудад үүссэн 47 хувь хүн, байгууллага аж ахуйн нэгжтэй холбоотой 11.9 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх, эзэн холбогдогчгүй, найдваргүй авлага өсөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.2.1 Илрүүлэлт:

Томилолтоор ажилласан албан хаагчдад байр, зам хоногийн зардлаас гадна цалин бодож олгохдоо хоол, унааны хөнгөлөлт 9.5 сая төгрөгийг давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хууль, журам мөрдөгдөхгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Томилолтоор ажилласан албан хаагчдад байр, зам хоногийн зардлаас гадна хоол, унааны мөнгө давхардуулан олгохгүй байх, хөдөлмөрийн дотоод журмыг хууль болон холбогдох дүрэм, журамтай нийцүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.3.1 Илрүүлэлт:

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хөрөнгө оруулалтын зардалд 362.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ”, мөн хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д “Нийслэл өөрийн төсвөөр дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Хууль, тогтоомж зөрчигдөх, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт санхүүжилт авч зарцуулахгүй, дээд шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлж байх гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 ХАРЬЯА ГАЗУУДАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.4.1 Илрүүлэлт:

Төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 971.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 638.6 сая төгрөгийн алдааг залруулж 14.1 сая төгрөгийн акт тогтоож, 59.7 сая төгрөгийн албан шаардлага, 259.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг үнэлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,070,334.7	6,766,091.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	149,260.2	374,856.3
АВЛАГА	57,915.1	39,559.4
УРЬДЧИЛГАА	5,560.0	11,200.0
БАРАА МАТЕРИАЛ	2,801,355.9	2,943,036.7
НӨӨЦИЙН БАРАА	3.5	
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,056,240.0	3,397,438.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	31,577,463.8	31,563,294.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,577,463.8	31,563,294.6
Биет хөрөнгө	29,850,365.2	29,650,301.8
Биет бус хөрөнгө	1,727,098.6	1,912,992.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	35,647,798.5	38,329,385.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	128,827.2	331,297.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	128,827.2	331,297.2
Өглөг	163.2	331,297.2
Урьдчилж орсон орлого	128,664.0	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	35,518,971.3	37,998,088.5
Засгийн газрын хувь оролцоо	35,518,971.3	37,998,088.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,432,657.3	16,432,657.3
Хуримтлагдсан үр дүн	16,077,223.4	18,587,867.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,009,090.6	2,977,564.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	35,647,798.5	38,329,385.7

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	40,258,098.0	45,119,165.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,862,274.6	7,223,931.1
Нийтлэг татварын бус орлого	6,862,274.6	7,223,931.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,395,823.4	37,895,234.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	39,402,562.2	42,355,457.5
УРСГАЛ ЗАРДАЛ	38,293,587.0	42,355,457.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,774,415.2	35,314,082.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,209,310.9	22,016,021.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,313,161.0	2,791,155.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,543,983.8	1,620,712.1
Хангамж, бараа материалын зардал	2,728,237.5	1,263,106.0
Нормативт зардал	440,336.6	532,882.7

Эд хогшил, урсгал засварын зардал	478,245.6	343,180.0
Томилолт, зочны зардал	447,234.5	490,045.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	740,096.2	712,921.7
Бараа үйлчилгээний бусад зардал	4,873,809.1	5,544,057.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,519,171.8	7,041,375.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,108,975.2	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	855,535.8	2,763,707.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,164,160.0	278,930.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-308,624.2	2,484,777.2

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	37,274,736.8	42,073,207.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,886,574.2	4,572,757.1
Нийтлэг татварын бус орлого	3,886,574.2	4,572,757.1
Тусламжийн орлого	0.0	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,388,162.6	37,500,450.7
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,015,147.5	38,475,051.3
УРСГАЛ ЗАРДАЛ	33,015,147.5	38,475,051.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,498,978.3	30,511,514.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,211,834.2	22,010,581.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,316,085.8	2,791,103.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,550,266.5	1,623,102.0
Хангамж, бараа материалын зардал	1,160,446.4	1,189,761.2
Нормативт зардал	835,237.5	842,432.2
Эд хогшил, урсгал засварын зардал	850,023.9	441,023.5
Томилолт, зочны зардал	461,264.8	486,945.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	799,596.6	778,634.3
Бараа үйлчилгээний бусад зардал	314,222.6	347,930.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,516,169.2	7,963,537.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,259,589.3	3,598,156.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,156,173.5	3,372,560.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,156,173.5	3,372,560.5
Дотоод эх үүсвэрээр	4,156,173.5	3,372,560.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,156,173.5	-3,372,560.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	103,415.8	225,596.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,844.5	149,260.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,260.3	374,856.3

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,857,020.7	0.0	32,857,020.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-131,700.0	0.0	-131,700.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	32,725,320.7	0.0	32,725,320.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,629,421.9	0.0	1,629,421.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,472,852.8	0.0	1,472,852.8
Тайлант үеийн үр дүн	-308,624.2	0.0	-308,624.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,518,971.2	0.0	35,518,971.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,866.7	0.0	25,866.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,544,837.9	0.0	35,544,837.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-31,526.6	0.0	-31,526.6
Тайлант үеийн үр дүн	2,484,777.2	0.0	2,484,777.2
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,998,088.5	0.0	37,998,088.5

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,936,078.5	33,656,176.4	2,279,902.1	93.7
УРСГАЛ ЗАРДАЛ	32,996,578.5	30,784,987.7	2,211,590.8	93.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,726,741.8	29,812,423.4	1,914,318.4	94.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,434,376.5	21,851,198.6	1,583,177.9	93.2
Үндсэн цалин	18,372,405.7	16,954,632.0	1,417,773.7	92.3
Нэмэгдэл	3,931,286.3	3,799,509.0	131,777.3	96.6
Унаа хоолны хөнгөлөлт	1,130,684.5	1,097,057.6	33,626.9	97.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,929,297.1	2,778,680.3	150,616.8	94.9
Тэтгэврийн даатгал	1,991,922.3	2,106,838.4	-114,916.1	105.8
Тэтгэмжийн даатгал	234,343.4	166,711.4	67,632.0	71.1
ҮОМШӨ-ний даатгал	187,474.7	133,890.6	53,584.1	71.4
Ажилгүйдлийн даатгал	46,869.0	34,080.2	12,788.8	72.7
Эрүүл мэндийн даатгал	468,687.7	337,159.8	131,527.9	71.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,701,836.8	1,620,029.9	81,806.9	95.2
Гэрэл, цахилгаан	273,201.0	240,707.5	32,493.5	88.1
Түлш, халаалт	771,486.1	761,988.5	9,497.6	98.8
Цэвэр, бохир ус	146,527.4	126,619.6	19,907.8	86.4
Байрны түрээс	510,622.3	490,714.4	19,907.9	96.1

Хангамж, бараа материалын зардал	1,187,946.7	1,161,231.9	26,714.8	97.8
Бичиг хэрэг	253,726.7	251,486.3	2,240.4	99.1
Тээвэр, шатахуун	503,650.4	505,367.5	-1,717.1	100.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	309,106.8	287,193.8	21,913.0	92.9
Ном, хэвлэл	0.0	147.6	-147.6	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,770.0	9,061.5	4,708.5	65.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	107,692.8	107,975.2	-282.4	100.3
Нормативт зардал	809,713.2	802,526.0	7,187.2	99.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	711,218.6	705,413.8	5,804.8	99.2
Хоол, хүнс	77,682.6	76,712.1	970.5	98.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,812.0	20,400.0	412.0	98.0
Эд хогшил, урсгал засварын зардал	451,212.5	444,484.8	6,727.7	98.5
Багаж, техник, хэрэгсэл	109,490.0	110,207.1	-717.1	100.7
Тавилга	53,580.0	53,578.6	1.4	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	45,890.8	42,247.5	3,643.3	92.1
Урсгал засвар	242,251.7	238,451.7	3,800.0	98.4
Томилолт, зочны зардал	461,477.4	455,340.4	6,137.0	98.7
Гадаад албан томилолт	0.0	6,495.5	-6,495.5	
Дотоод албан томилолт	458,977.4	445,885.6	13,091.8	97.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	2,500.0	2,959.3	-459.3	118.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	668,269.9	617,381.2	50,888.7	92.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	311,668.7	295,040.3	16,628.4	94.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,524.8	16,304.8	220.0	98.7
Даатгалын үйлчилгээ	34,213.5	32,389.8	1,823.7	94.7
Тээврийн хэрэгслийн татвар	12,180.9	9,797.7	2,383.2	80.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,056.3	2,812.2	244.1	92.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	163,608.9	145,420.3	18,188.6	88.9
Газрын төлбөр	6,664.6	5,013.8	1,650.8	75.2
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	120,352.2	110,602.3	9,749.9	91.9
Бараа үйлчилгээний бусад зардал	82,611.7	81,550.3	1,061.4	98.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,611.7	81,550.3	1,061.4	98.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,269,836.7	972,564.3	297,272.4	76.6
Бусад урсгал шилжүүлэг	1,269,836.7	972,564.3	297,272.4	76.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,156.6	25,156.6	0.0	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,119,378.0	825,261.3	294,116.7	73.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	125,302.1	122,146.4	3,155.7	97.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,939,500.0	2,871,188.7	68,311.3	97.7
Барилга байгууламж	2,939,500.0	2,871,188.7	68,311.3	97.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,936,078.5	33,659,376.4	2,276,702.1	93.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,733,123.5	33,453,521.4	2,279,602.1	93.6
Улсын төсвөөс санхүүжих	35,733,123.5	33,453,521.4	2,279,602.1	93.6

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	202,955.0	205,855.0	-2,900.0	101.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202,955.0	205,855.0	0.0	101.4
Тохируулгын дүн	0.0	222,396.0	0.0	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	149,260.3	0.0	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	374,856.3	0.0	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	27	27	0	100.0
Төсвийн байгууллага	27	27	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,113	1,949	164	92.2
Удирдах ажилтан	34	34	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	1,621	1,447	174	89.3
Үйлчлэх ажилтан	458	468	-10	102.2
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,113	1,949	164	92.2
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,543	1,363	180	88.3
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	2	0	2	0.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	568	586	-18	103.2

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,791,032.2
УРСГАЛ ЗАРДАЛ	3,687,187.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,338,550.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	689,069.4
Үндсэн цалин	648,302.3
Унаа хоолны хөнгөлөлт	26,117.9
Урамшуулал	14,450.1
Гэрээт ажлын хөлс	199.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,454.2
Тэтгэврийн даатгал	65,393.4
Тэтгэмжийн даатгал	51.2
ҮОМШӨ-ний даатгал	2.6
Ажилгүйдлийн даатгал	0.6
Эрүүл мэндийн даатгал	6.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000.0
Байрны түрээс	3,000.0
Хангамж, бараа материалын зардал	115,863.3
Бичиг хэрэг	60,293.9
Тээвэр, шатахуун	19,713.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,009.7
Ном, хэвлэл	10,424.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,422.6
Нормативт зардал	20,705.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,705.0

Эд хогшил, урсгал засварын зардал	216,122.2
Багаж, техник, хэрэгсэл	11,145.7
Тавилга	12,000.0
Урсгал засвар	192,976.4
Томилолт, зочны зардал	37,566.4
Дотоод албан томилолт	37,566.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,828,966.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,141,902.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,000.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	164.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	677,899.2
Бараа үйлчилгээний бусад зардал	361,804.0
Бараа үйлчилгээний бусад зардал	174,922.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	186,881.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	348,637.0
Бусад урсгал шилжүүлэг	116,774.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,220.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,200.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,354.1
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	231,862.9
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	231,862.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,844.5
Дотоод эх үүсвэрээр	103,844.5
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	103,844.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,790,870.6
Нэмэлт санхүүжилтийн орлого	3,790,870.6
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,120,664.1
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,588,449.6
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	81,756.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-161.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.2

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.20	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит			САГ-2020/04/СТА-ТТЗ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Томилолтоор ажилласан албан хаагчдад байр, зам хоногийн зардлаас гадна хоол, унааны мөнгө 9.5 сая төгрөгийг давхардуулан олгосон.	9.5	Зөвлөмж өгөх	МХЕГ-ын дарга Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Ахлах нягтлан бодогч	Н.Цагаанхүү Б.Оюунтуяа С.Бадамцэцэг
2	Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд Ховд аймгийн МХГ-ын барилгын гадна зам, талбай тохижилтын санхүүжилт 15.5 сая төгрөгийг 2016 оноос хойш байршуулсан байна.	15.5	Акт тогтоох		
3	Авлагын үлдэгдэлд 2006-2013 онуудад үүссэн 47 хувь хүн, байгууллага аж ахуйн нэгжтэй холбоотой 11.8 сая төгрөгийн эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага бүртгэлтэй байна.	11.9	Зөвлөмж өгөх		
4	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хөрөнгө оруулалтын зардалд 362.6 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна		Зөвлөмж өгөх		
5	Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 27 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн ба үүнээс 22 санхүүгийн тайланд зөрчилгүй, 4 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 1 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан. Аудитаар нийт 971.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 638.6 сая төгрөгийн алдааг залруулж 14.1 сая төгрөгийн акт тогтоож, 59.7 сая төгрөгийн албан шаардлага, 259.4 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.		Зөвлөмж өгөх		
	Нийт дүн	36.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/76
САГ-2020/04/СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын гадна зам, талбайн тохижилтын ажлын санхүүжилт 15,500,000 төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулж 2016 оноос хойш үлдэгдэлтэй байна. Гэвч уг барилгын гадна талбай нь нийтийн эзэмшлийн талбай болохыг Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын автозамын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ..." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Барьцаа дансанд байршиж байгаа хэрэгжих боломжгүй хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт 15,500,000 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Оюунтуяа, ахлах нягтлан бодогч С.Бадамцэцэг нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]*
Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР *[Signature]*
Б.СЭРЖМЯДАГ
АУДИТОР *[Signature]*
А.ДАВААДОРЖ

АКТЫГ:
ЗӨВШӨӨРСӨН:
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА *[Signature]*
Н.ЦАГААНХҮҮ
САНХҮҮ, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.ОЮУНТУЯА
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
С.БАДАМЦЭЦЭГ

Акт, албан шаардлага, биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\03265AG2 Docx

001090203